

“НОЦ БЕТОН ЗУУРМАГ” ХХК

**ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 3-Р ХОРООНЫ НУТАГТ ОРШИХ
БЕТОН ЗУУРМАГИЙН ҮЙЛДВЭРИЙН 2023 ОНД
ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**



УЛААНБААТАР ХОТ

2023 ОН

ГАРЧИГ

НЭГ.ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	3
1.1 Төслийн нэр.....	3
1.2 Төслийн зорилго.....	3
1.3 Төсөл хэрэгжүүлэгчийн нэр хаяг.....	3
1.4 Төслийн байршил.....	3
1.5 Төслийн төлөвлөлт, хүчин чадал	4
1.6 Үйлдвэрийн технологи, түүхий эд, материалын хэрэглээ.....	6
1.6.1 Үйлдвэрийн технологи.....	6
1.6.2 Үндсэн ба туслах түүхий эд материалын хэрэглээ.....	6
1.6.3 Ус хангамж хэрэглээ.....	8
1.6.4 Цахилгаан эрчим хүч, дулаан хангамж.....	8
1.7 Эцсийн бүтээгдэхүүн.....	9
1.8 Хог хаягдал.....	10
ХОЁР. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТАГ ДЭВСГЭРИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ- ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ.....	12
2.1. Цаг уур, уур амьсгалын онцлог.....	12
2.1.1 Агаарын температур.....	12
2.1.2 Хөрсний температур.....	12
2.1.3 Хур тунадас.....	12
2.1.4 Салхи.....	12
2.1.5 Агаарын даралт, чийгшил.....	12
2.2. Агаарын чанарын өнөөгийн байдал.....	13
2.3. Хөрсөн бүрхэвчийн өнөөгийн байдал.....	14
2.4. Гадаргын болон газар доорх усны нөөц, онцлог, чанар.....	17
2.4.1. Гадаргын усны горим.....	17
2.4.2. Гидрогеологийн нөхцөл.....	18
2.4.3. Газрын доорх усны нөхөн сэргээгддэг нөөц.....	19
2.4.4. Газрын доорх усны чанар.....	20
2.5. Ургамлан нөмрөгийн өнөөгийн байдал.....	20
2.6. Амьтны аймгийн тархалт, зүйлийн бүрдэл.....	22
2.7. Нийгэм, эдийн засгийн өнөөгийн байдал.....	22
ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТУХАЙ ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ.....	26
ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНЫ ГОЛ ЗОРИЛТ.....	28
ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	29
ЗУРГАА. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	31
ДОЛОО. ОСОЛ ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	32
НАЙМ. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	33
ЕС. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР.....	35
АРАВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	36
АРВАН НЭГ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСЭД ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	37
АРВАН ХОЁР. 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НЭГДСЭН ТӨСӨВ.....	38

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Бетон зуурмагийн үйлдвэрийн үйл ажиллагаа явуулж буй талбайн эргэлтийн цэгүүдийн солбицол.....	3
Хүснэгт 2. Бетон зуурмагийн үйлдвэрийн түүхий эд туслах материалын жилийн хэрэглээ.....	7
Хүснэгт 3. Үйлдвэрийн технологи болон унд ахуйн ус хэрэглээ (Ус хэрэглээний нормоор).....	8
Хүснэгт 4. Агаарын чанарын шинжилгээний дүн.....	14
Хүснэгт 5. Хөрсний химийн үндсэн шинжүүд.....	16
Хүснэгт 6. Хөрсний механик.....	16
Хүснэгт 7. Хөрсөн дэх зарим хүнд металлын агууламж (мг/кг).....	16
Хүснэгт 8. Сав газрын ус агуулагч үе, бүрдэл болон бүсийн гидрогеологийн зарим үзүүлэлт.....	18
Хүснэгт 9. Сав газрын доорх усны нөхөн сэргээгддэг нөөц.....	19
Хүснэгт 10. Хан-Уул дүүргийн 2018 оны төсвийн нийт орлого, сая төгрөг.....	24
Хүснэгт 11. Хан-Уул дүүргийн 2018 оны төсвийн нийт зарлага, сая төгрөг.....	25
Хүснэгт 12. Болзошгүй нөлөөллийн жагсаалт.....	26

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Үйлдвэрийн байршил.....	4
Зураг 2. Бетон зуурмагийн үйлдвэрийн суурин тоног төхөөрөмж.....	5
Зураг 3. Бетон зуурмагийн үйлдвэрийн орчны газар ашиглалтын өнөөгийн байдал	5
Зураг 4. Бетон зуурмагийн үйлдвэрийн технологийн схем.....	6
Зураг 5. Түүхий эд (элс,хайрга, дайрга)-ийн талбай.....	7
Зураг 6. Үйлдвэрийн усны нөөцийн танкууд.....	7
Зураг 7. Нэмэлт бодис хадгалах сав.....	7
Зураг 8. Дамжуулах бункер, туузан дамжуулагч.....	7
Зураг 9. Бетон зуурмагийн үйлдвэрийн талбайд байрлах гүний худаг.....	8
Зураг 10. Бэлэн болсон бетон зуурмагийг зориулалтын холигч тээврийн.....	9
Зураг 11. Бетоныг барилгын талбайд буулгаж буй байдал.....	9
Зураг 12. Үйлдвэрийн чанарын хяналтын лаборатори.....	10
Зураг 13. Ахуйн хатуу хог хаягдлын цэг.....	11
Зураг 14. Ажилчдын бие засах газар, ариун цэврийн өрөө, бохирын цооног.....	11
Зураг 15. Тунгаагуурын сан.....	11
Зураг 16. Цасан болон шороон шуургатай өдрийн тоо.....	13
Зураг 17. Монгол орны хөрс-газарзүйн мужлалтын зураг.....	14
Зураг 18. Бетон зуурмагийн үйлдвэрийн талбайн орчны хөрсний зураглал.....	15
Зураг 19. Бетон зуурмагийн үйлдвэрийн талбайн газрын гадаргын элэгдэл доройтлын өнөөгийн байдал.....	15
Зураг 20. Төслийн талбайн орчны гадаргын усан сүлжээний зураглал.....	17
Зураг 21. Үйлдвэрийн талбайн орчны газрын доорх усны нөхөн сэргээгдэх нөөцийн тархалт.....	20
Зураг 22. Үйлдвэрийн хашааны гадна талын ургамжилтын байдал.....	21
Зураг 23. ХУД-ийн газрын нэгдмэл сангийн ангилал.....	22
Зураг 24. ХУД-ийн 3-р хорооны нутаг дэвсгэрийн газар ашиглалтын өнөөгийн байдал.....	25

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн нэр

Бетон зуурмагийн үйлдвэрийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ-2023)

1.2. Төслийн зорилго

Энэхүү бетон зуурмагийн үйлдвэр нь чанарын шаардлага хангасан түүхий эд материалаар сүүлийн үеийн дэвшилтэт, бүрэн автомат техник тоног төхөөрөмжийг ашиглан олон улсын стандартад нийцсэн дээд зэргийн чанартай бетон зуурмагийг үйлдвэрлэж дотоодын зах зээлд нийлүүлэх, улмаар улсын төсөвт төлөх татварын орлогыг нэмэгдүүлэх, шинээр ажлын байр бий болгох, барилгын салбарыг хөгжүүлэхэд өөрийн хувь нэмрээ оруулах зорилготой үйл ажиллагаа явуулдаг.

1.3. Төсөл хэрэгжүүлэгчийн нэр хаяг

“Ноц бетон зуурмаг” ХХК
 Улсын бүртгэлийн дугаар: 9011442083
 Регистрийн дугаар: 5809665
 Хаяг: Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 15-р хороо, Өнөр хороолол 20, 314 тоот
 Утас: 91917137


1.4. Төслийн байршил

“Ноц бетон зуурмаг” ХХК-ийн “Бетон зуурмагийн үйлдвэр” нь Нийслэлийн Хан-Уул дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэрт, ТЭЦ-3-ын баруун талд, үйлдвэрлэлийн бүсэд байрлах “Эн Өү Ти Эс” ХХК-ийн эзэмшил нийт 7699 м² талбайг түрээслэн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулж байна. Түрээслэн ашиглаж буй газрын эргэлтийн цэгүүдийн координатыг хүснэгт 2-1-ээр, үйлдвэрийн байршлыг зураг 2-1-т тус тус харуулав.

Хүснэгт 1. Бетон зуурмагийн үйлдвэрийн үйл ажиллагаа явуулж буй талбайн эргэлтийн цэгүүдийн солбицол

Цэгийн дугаар	Өргөрөг	Уртраг	Цэгийн Дугаар	Өргөрөг	Уртраг
Нэгж талбарын дугаар -1780912065, Газрын хэмжээ 4200 м ²					
1	47°53'43.28"N	106°51'18.06"E	9	47°53'45.01"N	106°51'21.29"E
2	47°53'44.20"N	106°51'17.89"E	10	47°53'45.13"N	106°51'22.49"E
3	47°53'44.26"N	106°51'18.49"E	11	47°53'44.28"N	106°51'22.76"E
4	47°53'45.11"N	106°51'18.34"E	12	47°53'44.15"N	106°51'21.49"E
5	47°53'45.25"N	106°51'19.57"E	13	47°53'43.67"N	106°51'21.60"E
6	47°53'45.39"N	106°51'20.79"E	14	47°53'43.53"N	106°51'20.41"E
7	47°53'44.52"N	106°51'20.99"E	15	47°53'43.40"N	106°51'19.24"E
8	47°53'44.57"N	106°51'21.39"E			
Нэгж талбарын дугаар -1780912214, Газрын хэмжээ 3499 м ²					
1	47°53'45.13"N	106°51'22.49"E	10	47°53'46.88"N	106°51'22.10"E

2	47°53'45.01"N	106°51'21.29"E	11	47°53'47.12"N	106°51'23.53"E
3	47°53'45.43"N	106°51'21.20"E	12	47°53'46.42"N	106°51'23.76"E
4	47°53'45.91"N	106°51'21.08"E	13	47°53'46.12"N	106°51'22.41"E
5	47°53'45.74"N	106°51'20.00"E	14	47°53'46.10"N	106°51'22.32"E
6	47°53'45.53"N	106°51'18.68"E	15	47°53'46.01"N	106°51'22.35"E
7	47°53'46.32"N	106°51'18.55"E	16	47°53'45.98"N	106°51'22.16"E
8	47°53'46.98"N	106°51'21.42"E	17	47°53'45.56"N	106°51'22.31"E
9	47°53'46.79"N	106°51'21.53"E	18	47°53'45.56"N	106°51'22.33"E



Зураг 1. Үйлдвэрийн байршил

1.5. Төслийн төлөвлөлт, хүчин чадал

“Бетон зуурмагийн үйлдвэр” нь 2014 оны 08 сараас үйл ажиллагаа явуулж эхэлсэн бөгөөд M100-M500 маркын бетон зуурмагийг үйлдвэрлэн дотоодын хэрэглэгчдэд нийлүүлж байна.

Энэхүү үйлдвэр нь БНХАУ-ын “ZOOMLION” фирмийн бетон зуурмагийн бүрэн автомат суурин тоног төхөөрөмжөөр тоноглогдсон. Уг тоног төхөөрөмж нь хүчин чадал сайтай, зурах эд анги, хугацааны тохиргоотой, бүтээгдэхүүнээ гаргах үйлдэлтэй, түүхий эдүүдийн орц найрлагыг цахилгаан жинлүүр, компьютерийн программын хяналтан дор хуваарилдаг бүрэн автомат ажиллагаатай юм. Мөн үйлдвэрлэл явуулахад шаардлагатай нэмэлт тоног төхөөрөмж, авто пүү, үйлдвэрлэлийн үйл ажиллагааг бүрэн хангахуйц цахилгааны дэд станцтай бөгөөд шаардлагатай түүхий эд, материалын нөөцийг харилцагч байгууллагуудаас тасралтгүй нийлүүлж үйлдвэрлэлийн үйл ажиллагааг тогтвортой явуулдаг.

Жил бүрийн 10-р сарын 20-ноос дараа оны 3-р сарын 20 хүртэлх хугацаанд үйлдвэрийн үйл ажиллагааг бүрэн зогсоож, жилд дунджаар 215 хоног идэвхитэй

үйл ажиллагаа явуулдаг. Бүрэн хүчин чадлаараа ажиллах үед цагт 120 м³ бүтээгдэхүүн үйлдвэрлэн гаргах хүчин чадалтай. Одоогийн байдлаар нийт 26 хүнийг ажлын байраар ханган ажиллуулж байгаагаас инженер техникийн ажилтан 6, үйлдвэрийн ажилчин 6, жолооч 14 байна.



Зураг 2. Бетон зуурмагийн үйлдвэрийн суурин тоног төхөөрөмж



Зураг 3. Бетон зуурмагийн үйлдвэрийн орчны газар ашиглалтын өнөөгийн байдал

1.6. Үйлдвэрийн технологи, түүхий эд, материалын хэрэглээ

1.6.1. Үйлдвэрийн технологи


Бетон зуурмаг гэдэг нь цемент, ус, элс, хайрга, нэмэлт бодис зэрэг материалуудыг урьдчилан бэлтгэсэн найрлагаар хэмжиж холиод найруулсан бэхжээгүй зуурмагийг хэлнэ.

Бэлэн болсон зуурмагийг тусгай зориулалтын зуурагч машинаар хэрэглэгчдэд хүргэх бөгөөд энэ нь бетон зуурмагийн шингэн чанарыг хадгалж түүхий эдүүдийг холигдсон байдлаар хүргэдэг давуу талтай.

Үйлдвэрлэлийн технологийн үндсэн үйл ажиллагаа нь:

- Түүхий эд материалыг хүлээн авах
- Хадгалах
- Зөөж тээвэрлэх, бэлтгэх
- Зуурмагийг зуурах
- Бэлэн зуурмагийг тээвэрлэн хэрэглэгчдэд хүргэх гэсэн үе шат, дарааллаар явагддаг.

Бетон зуурмагийн үйлдвэрийн технологийн схемийг доорх зурагт үзүүлэв.



Зураг 4. Бетон зуурмагийн үйлдвэрийн технологийн схем

1.6.2. Үндсэн ба туслах түүхий эд материалын хэрэглээ

Үйлдвэрийн үндсэн түүхий эдүүд нь цемент, элс, дайрга (5-10 мм, 10-20 мм), нэмэлт гэсэн материалууд байх ба үйлдвэрийн тээврийн хэрэгсэл, машин механизмуудын ажиллагаанд дизель түлш, тос ашигладаг. Эдгээр түүхий эд материалуудыг дотоодын зах зээлээс харилцагч байгууллагуудтай байгуулсан

түүхий эд нийлүүлэх гэрээний дагуу худалдан авч ашигладаг ба жилийн хэрэглээг доорх хүснэгтээр харуулав.

Хүснэгт 2. Бетон зуурмагийн үйлдвэрийн түүхий эд, туслах материалын жилийн хэрэглээ

д/д	Түүхий эд, материал нийлүүлэгч байгууллагуудын нэр	Материалын нэр, төрөл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
1	“Батжилт энх” ХХК	Элс	м ³	13400
2	“Хөтөл Цемент Шохой” ХХК, “Мөнхийн баян гал” ХХК	Цемент	тн	6200
3	”IZKON” ХХК	Нэмэлт бодис (PC-2, PC-3)	тн	68
4	ЦэЦэ импекс ХХК, “Баруун туруун ” ХХК	Дайрга (5-10мм, 10-20мм)	м ³	9787
5	“Магнай Трейд” ХХК	Тос	тн	110
6		Дизель түлш	кг	250-400



Зураг 5. Түүхий эд (элс, хайрга, дайрга)-ийн талбай



Зураг 6. Үйлдвэрийн усны нөөцийн танкнууд



Зураг 7. Нэмэлт бодис хадгалах сав



Зураг 8. Дамжуулах бункер, туузан дамжуулагч

1.6.3. Ус хангамж, хэрэглээ

“Бетон зуурмагийн үйлдвэр”-ийн үйл ажиллагааны үед үйлдвэрлэлийн технологи болон ажилчдын унд ахуйн зориулалтаар ус ашиглах ба технологийн ус хэрэглээг үйлдвэрийн талбай дахь 2 л/с-ийн ундаргатай гүний худгаас хангадаг. Үйлдвэрийн үндсэн хүчин чадал нь 120 м³/цаг боловч хэрэглэгчийн захиалга болон цаг уурын нөхцөлөөс хамааран хоногт дунджаар 60м³ бетон зуурмаг үйлдвэрлэдэг. Харин унд ахуйн ус хэрэглээг толгой компани болох “Эн Өү Ти Эс” ХХК-ийн БГД-ийн 4-р хороонд байрлах үйлдвэрийн гүний худгийн уснаас зөөврөөр хангаж байна.

Бетон зуурмагийн үйлдвэрийн унд ахуй болон технологийн усны хэрэглээг БОНХАЖСайдын А/301 дүгээр тушаалаар батлагдсан “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм”-ын дагуу тооцоход хоногт 21.9 м³, жилд 4708.5 м³ ус хэрэглэх тооцоо гарч байна (Хүснэгт 3). Гүний худаг нь хоногт 172.8 м³ ус гаргах хүчин чадалтай бөгөөд үйлдвэрийн технологийн ус хэрэглээг бүрэн хангах боломжтой.

Хүснэгт 3. Үйлдвэрийн технологи болон унд ахуйн ус хэрэглээ (Ус хэрэглээний нормоор)

№	Ус хэрэглээний төрлүүд	Хоногт үйлдвэрлэх бетон зуурмагийн хэмжээ, м ³	Ажилчдын тоо	Ус хэрэглээний норм (А/301 тушаал)	Хоногийн ус хэрэглээ, м ³	Жилд ажиллах хоногийн тоо	Жилийн ус хэрэглээ, м ³
1	Технологи	60	-	0.3 м ³ /м ³ бетон	18.0	215	3870.0
2	Унд, ахуй	-	26	150 л/хоног	3.9	215	838.5
Нийт ус хэрэглээ					21.9	-	4708.5



Зураг 9. Бетон зуурмагийн үйлдвэрийн талбайд байрлах гүний худаг

1.6.4. Цахилгаан эрчим хүч, дулаан хангамж

Бетон зуурмагийн үйлдвэр нь “УБЦТС” ТӨХК-тай байгуулсан гэрээний дагуу цахилгаан эрчим хүчний төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон. Харин улирлын чанартай ажиллаж, намар үйл ажиллагаагаа зогсоодог тул дулааны шугам сүлжээнд холбогдоогүй болно. Шаардлагатай үед ажилчдын оффисийн барилгыг цахилгаан халаагуур ашиглан халаадаг.

1.7. Эцсийн бүтээгдэхүүн

Дэлхийн чанарын стандарт болох ISO 9001, байгаль орчинд хор нөлөөгүйг батлах ISO 14001, Монгол усун “Бетон зуурмаг. Техникийн шаардлага MNS 1185:1998” стандартын шаардлага хангасан M100-M500 маркийн бетон зуурмаг үйлдвэрлэн иргэн, үйлдвэр, ХАА, орон сууцны барилга угсралтын талбайд захиалагчийн захиалга, хүсэлтийн дагуу зориулалтын миксер машинуудаар тээвэрлэн хүргэж өгөх бөгөөд жилд дунджаар 10-12 мян.м³ бетон үйлдвэрлэн зах зээлд нийлүүлдэг.



Зураг 10. Бэлэн болсон бетон зуурмагийг зориулалтын холигч тээврийн хэрэгсэлд юүлж буй байдал



Зураг 11. Бетоныг барилгын талбайд буулгаж буй байдал

Үйлдвэрийн эцсийн бүтээгдэхүүний чанарыг үйлдвэрийн дэргэдэх бүтээгдэхүүний чанарын хяналтын иж бүрэн тоног төхөөрөмж бүхий лабораторид шалгаж, чанар стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэд нийлүүлдэг бөгөөд 2014 оноос Барилга архитектур корпорацийн итгэмжлэгдсэн лабораторитой хамтран ажиллаж чанарын шинжилгээг давхар хийлгэн ажиллаж байна. Энд бетон зуурмагийн гол түүхий эд болох цемент, элс, хайрганы чанар болон зуурмагийн чанарт хяналт тавьж, байнгын туршилт шалгалтыг явуулдаг. Хяналт, туршилтыг “Бетон зуурмагийг турших арга MNS 1170:85”, “Барилгын зуурмаг турших арга MNS 2120:99” стандартын дагуу хийж доорх үзүүлэлтүүдийг тодорхойлдог. Үүнд:

Цемент:

- Хэвийн өтгөрөлт
- Барьцалдаж эхлэх, дуусах хугацаа
- 0.08 мм шигшүүр дээрх үлдэгдэл
- Шахалт, гулзайлтын бат бэх (3, 7, 28 хоног)

Элс:

- Чийглэг
- Асгаасан нягт
- Нягт
- Ширхэглэлийн бүрэлдэхүүн
- Тоосорхог хольцын хэмжээ
- Ширхэгийн модуль
- Элсэн дээрх хайргын хэмжээ
- Ус шингээлт
- Ширхэг хоорондын зай

Хайрга:

- Чийглэг
- Асгаасан нягт
- Нягт
- Ширхэг хоорондын зай
- Нимгэн үзүүрлэг хэсэг
- Ширхэгийн хэмжээ, бүрэлдэхүүн
- Элэгдэх чанар
- Хайрган дахь элсний хэмжээ
- Тоосорхог хольцын хэмжээ

Бетон зуурмаг:

- Конусын суулт (хөдөлгөөнт чанар)
- Барилгын талбай дээр хийгдэнэ
- Агаарын агууламж (нүх сүвийн хэмжээ)
- Температур

Бетон:

- Шахалтын бат бэх (3, 7, 28 хоног)




Зураг 12. Үйлдвэрийн чанарын хяналтын лаборатори

1.8. Хог хаягдал

Бетон зуурмагийн үйлдвэрийн үйл ажиллагааны үед ахуйн хатуу, шингэн хаягдал, бетон зуурмаг тээвэрлэгч “Мixer” машиныг угааж цэвэрлэхэд гарах шингэн хаягдал, үйлдвэрийн машин механизм, тоног төхөөрөмжийн ашиглалт, засвар үйлчилгээнээс үүсэх тос тосолгооны материалын хаягдал зэрэг аюултай болон энгийн хаягдлууд үүснэ. Ахуйн хатуу хаягдал хоногт 0.026 тн үүсэх ба үйлдвэрийн хашаан дахь хогийн түр цэгт хуримтлуулж, ХУД-н Тээвэрлэлт үйлчилгээний төв ОНӨААТҮГ-тай байгуулсан “Хог хаягдал ачиж, тээвэрлэх гэрээ”-ний дагуу төвлөрсөн хаягдлын цэг рүү ачуулдаг. Ахуйн шингэн хаягдал хоногт 2.7м³ орчим үүсэх ба 8 м³-ийн багтаамжтай бохирын цооногт хуримтлуулж бохир соруулах машинаар соруулан зайлуулдаг.

Бетон зуурмаг тээвэрлэгч Мixer машиныг угааж цэвэрлэхэд гарах технологийн шингэн хаягдлыг 3 дамжлага бүхий тунгаагуурын санд хуримтлуулж эцсийн байдлаар тунаж шүүгдсэн усыг дахин эргэлтийн системээр ашиглахаар төлөвлөн үйлдвэрийн талбайд 8 м өргөн, 10 м урт, 2 м гүнтэй, 160 м³-ийн багтаамжтай бетон материал бүхий хаягдлын сан (Зураг 15) байгуулан ашиглаж байна.

Үйлдвэрийн машин механизм, тоног төхөөрөмжийн ашиглалт, засвар үйлчилгээнээс үүсэх ашигласан тосны хаягдлыг “Тэнүүн–Өлзий” ХХК-д нийлүүлдэг. Хартугалгатай батерей, аккумуляторын хаягдлыг Налайх дүүргийн Хятадын хөрөнгө оруулалттай аккумуляторын үйлдвэрт өөрийн унаагаар хүргэж шилжүүлдэг.



Зураг 13. Ахуйн хатуу хаягдлын цэг



Зураг 14. Ажилчдын бие засах газар,
ариун цэврийн өөрөө, бохирын цооног



Зураг 15. Тунгаагуурын сан

ХОЁР. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТАГ ДЭВСГЭРИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

2.1. Цаг уур, уур амьсгалын онцлог

2.1.1. Агаарын температур

Улаанбаатар хот орчмын уур амьсгалын онцлог нь ерөнхийдөө эх газрын эрс тэс шинжтэй. Агаарын сарын дундаж температурын агууриг нь 45.3°C байна. Үнэмлэхүй агууриг нь 86.2°C хүрдэг. Агаарын температур тодорхой илэрсэн жил хоногийн явцтай байдаг. Жилийн явцад агаарын температурын хамгийн их утга нь зуны 7 дугаар сард, бага утга нь өвөл 1 дүгээр сард тус тус ажиглагддаг байна. Жилийн хамгийн дулаан 7 дугаар сарын дундаж температур 19.6°C дулаан, хамгийн хүйтэн 1 дүгээр сарын дундаж температур -25.7°C хүйтэн байна. Агаарын үнэмлэхүй хамгийн их температур 39.5°C хүрч дулаарсан байна. Үнэмлэхүй хамгийн бага температур -46.7°C - -25.7°C хүрч хүйтэрсэн байна.

2.1.2. Хөрсний температур

Хөрсний гадаргын жилийн дундаж температур $+1.3^{\circ}\text{C}$ байна. Жилийн хамгийн хүйтэн 1 дүгээр сарын хөрсний гадаргын дундаж температур -5.1°C хүйтэн байна. Хамгийн дулаан 7 дугаар сарын хөрсний гадаргын дундаж температур $+23.9^{\circ}\text{C}$ дулаан байна.


2.1.3. Хур тунадас

Улаанбаатар хот орчимд жилд дунджаар 252.9 мм хур тунадас унадаг ба үүний 89.6-93.4% нь 4-9 сард, үлдсэн хэсэг нь бусад саруудад оногддог. Хүйтэн улирлын хур тунадас 11-34 мм байдаг нь цасан бүрхэвчийн зузаан бага байх үндсэн хүчин зүйл бөгөөд нарны цацраг харьцангуй их, агаарын чийг дутагдалтай учир өвөл ч гэсэн уурших үзэгдэл хүчтэй байдаг. Үүний улмаас цасны зузаан өвлийн турш хуримтлагдаж нэмэгдэх нь бага байна.

2.1.4. Салхи

Салхины жилийн дундаж хурд 2.4 м/с байна. Салхины хурдны их утга нь хавар намрын улиралд ажиглагдах бөгөөд 4-5 дугаар сард 3.8-3.9 м/с хүрдэг байна. Өвлийн улиралд салхины хурдны бага утга нь ажиглагдана. Салхины хамгийн их хурд Улаанбаатар станц орчимд 13 м/с хүрсэн байна. Манай орны бусад нутгийн нэгэн адил хойд, баруун хойд зүгийн салхи зонхилно. Улаанбаатар хот орчимд геоморфологийн онцлогоос хамааран өвөлдөө баруун хойд зүгийн салхи, зундаа зүүн хойд, зүүн зүгийн салхи зонхилдог. Салхины олон жилийн дундаж хурд нь 1.5-3.0 м/с, заримдаа 4.5-5.2 м/с хүрдэг. Өвөлдөө бараг салхигүй тогтуун байх учраас бичил цаг уурын өвөрмөц нөхцөл бүрддэг.

Улаанбаатар хот орчимд 2008-2018 онуудад жилийн 34-99 өдөр цасан болон шороон шуургатай байсан байна.



Зураг 16. Цасан болон шороон шуургатай өдрийн тоо

2.1.5. Агаарын даралт, чийгшил

Жилийн дундаж харьцангуй чийгшил 61% байна. Өвөл зуны саруудад жилдээ 2 удаа харьцангуй чийгийн их утга ажиглагдаж 1 дүгээр сард 72%, 8 дугаар сард 56% байдаг. Харин хавар намрын улиралд бага утга нь ажиглагдаж 41-56% болтлоо буурдаг байна.

Хамгийн өндөр харьцангуй чийг 12, 1-р сард ажиглагдана. 3-р сараас харьцангуй чийгийн хэмжээ үлэмж буурч 60 хувиас доошлон, зарим өдрүүдэд 20-30% хүртэл буурдаг. Харьцангуй чийгийн хэмжээ зундаа ихсэж ирэх ба намраас тухайлбал бууралт 10-р сараас эхэлдэг. Улаанбаатар хотын жилийн дундаж

агаарын даралт 868 гПа ба хавар 4-5 сард хамгийн бага 864-866 гПа, өвөл 12, 1-р сард хамгийн их буюу 871-872 гПа байна.

2.2. Агаарын чанарын өнөөгийн байдал

Ноц бетон зуурмагийн үйлдвэр нь ХУД-ийн 3-р хорооны нутаг дэвсгэрт, ТЭЦ-3-ын баруун талд 500 метр орчим зайд байрладаг. Үйлдвэрийн үйл ажиллагаа явуулж буй нутаг дэвсгэр нь томоохон үйлдвэр, аж ахуйн нэгжүүд төвлөрөн үйл ажиллагаа явуулдаг үйлдвэрлэлийн бүс бөгөөд антропоген болон техноген нөлөөллөөр байгалийн унаган төрх нь бүрэн өөрчлөгдөж хөрс, газрын гадарга нь эвдэрч доройтсон, хуримтлагдах нөлөөлөл ихтэй. Ялангуяа эвдэрсэн зам талбайгаас агаарт их хэмжээний тоосжилт үүсэж тухайн орчны агаарын чанарт сөргөөр нөлөөлдөг.

Ноц бетон зуурмагийн үйлдвэрийн үйлд ажиллагаа явуулж буй эдэлбэр газар нь мөн адил ургамлан нөмрөг, ногоон байгууламж байхгүй бөгөөд сул шороо бүхий зам талбайгаас салхины үйлчлэл, тээврийн хэрэгслүүдийн зорчих хөдөлгөөн, түүхий эд материалыг бэлтгэх, зөөх зэрэг үйл ажиллагаагаар тоосжилт үүсэж орчны агаарыг бохирдуулдаг. Иймд үйлдвэрийн орчны агаарын чанарыг тодорхойлохын тулд агаарт агуулагдах түгээмэл бохирдуулагчид болох Хүхэрлэг хий (SO₂), Азотын давхар исэл (NO₂), нийт тоосонцрын (TSP) нэг удаагийн хэмжилт хийж Монгол улсад мөрдөгдөж буй гадаад орчны агаарын чанарын стандартын зөвшөөрөгдөх дээд хэмжээтэй харьцуулав.


Үйлдвэрийн талбайн агаар дахь бохирдуулагч бодисуудын нэг удаагийн буюу 20 минутын дундаж хэмжилтийн үр дүнгээс үзэхэд нийт тоос нь “Агаарын чанарын техникийн ерөнхий шаардлага, агаарын чанарын стандарт MNS 4585:2016”-д заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс 79.2 хувиар давсан үзүүлэлттэй (0.896 мг/м³), харин хүхэрлэг хий болон азотын давхар ислийн агууламж нь стандартын ЗДХ-ээс бага үзүүлэлттэй тус тус гарсан.

Хүснэгт 4. Агаарын чанарын шинжилгээний дүн

№	Хэмжилт хийсэн цэгүүд	Нийт тоосны агууламж /TSP/	Хүхэрлэг хий /SO ₂ /	Азотын давхар исэл /NO ₂ /
		мг/м ³		
1	Цэг -1. Бетон зуурмагийн үйлдвэрийн талбай	0.896	0.011	0.033
MNS 4585:2016 зөвшөөрөгдөх дээд хэмжээ		0.500	0.450	0.200


2.3. Хөрсөн бүрхэвчийн өнөөгийн байдал

Улаанбаатар хотын нутаг дэвсгэр нь Монгол орны хөрс–газарзүйн мужлалын хувьд Хангайн их мужийн Өндрийн бүсшилтэй нутгийн Хэнтийн мужийн Хэнтийн захын (39) тойрогт хамаарагдана(МУ-ын Үндэсний Атлас, 2009).



Зураг 17. Монгол орны хөрс-газарзүйн мужлалтын зураг

Хөрсний хэв шинж, элэгдэл доройтол: Үйлдвэрийн эдэлбэр газарт байгалийн тогтцоороо хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй аллювийн нугын сулавтар хөгжилтэй хөрс тархсан боловч нийт үйл ажиллагаа явуулж буй талбайн 76 хувь нь үйлдвэрийн суурин тоног төхөөрөмж, барилга байгууламж, хатуу хучилттай зам талбай, түүхий эд хадгалах талбай, автомашины зогсоолын зориулалтаар ашиглагдаж, үлдсэн 24 хувь нь үйлдвэрийн технологи, хүнд даацын машин механизмын нөлөөгөөр багаас дунд зэрэглэлээр элэгдэж доройтон хөрсөн бүрхэвчийн өнгөн хэсэг нь халцарч зулгарсанаас хөрсний механик бүрэлдэхүүн, бүтэц хэв шинж нь өөрчлөгдөн бүхэлдээ сул шороон гадаргатай болсон байна. Үйлдвэрийн талбайн хөрсний хэв шинжийн зураглалыг Зураг 18-д, газрын гадаргын элэгдэл, эвдрэлийн өнөөгийн байдлыг Зураг 19-т тус тус үзүүлэв.



Зураг 18. Бетон зуурмагийн үйлдвэрийн талбайн орчны хөрсний зураглал



Зураг 19. Бетон зуурмагийн үйлдвэрийн талбайн газрын гадаргын элэгдэл доройтлын өнөөгийн байдал

Хөрсний физик, химийн шинж чанар: Үйлдвэрийн талбайн хөрсний химийн задлан шинжилгээний үр дүнгээс үзэхэд хөрсний урвалын орчин нь хүчтэй ($pH=9$) шүлтлэг шинжтэй, ялзмагийн агууламж нь 1.59 % буюу бага, хөрсний цахилгаан дамжуулах чанар болон давсны эзлэх хувь бага, 100 гр хөрсөн дэх хөдөлгөөнт фосфор 1.8 мг буюу Мачигины ангиллаар дунд, солилцох кали 10 мг буюу Мачигины ангиллаар бага хангамжтай, шингээгдсэн сууриудын нийлбэр хангалттай байна. Хөрсний ерөнхий үржил шимийн түвшин бага гарсан болно (Хүснэгт 5).

Харин хөрсний физик шинж чанарыг тодорхойлсон үр дүнгээс үзэхэд элс, тоос, шаврын харьцаа (85.9:10.9:14.3) нь тухайн хөрсийг элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй болохыг илтгэх бөгөөд том ширхэгтэй элсний эзлэх хувь харьцангуй их (85.9%) байна (Хүснэгт 6).

Хүснэгт 5. Хөрсний химийн үндсэн шинжүүд

Дээжний дугаар	Дээж авсан гүн /см/	рН	Давс , %	ЦДЧ,d s/m	Ялзмаг %	СаСО ₃ , %	NO ₃ , %	Солилцох суурь, мг-экв/100 гр		Шим тэжэлийн элементүүд мг/100 гр	
								Ca	Mg	P ₂ O ₅	K ₂ O
Дээж-01	0-20	9	0.011	0.042	1.59	0.16	0.03	7	6	1.8	10

Хүснэгт 6. Хөрсний механик бүрэлдэхүүн

Дээжний дугаар	Дээж авсан гүн /см/	Механик ширхэгүүд, % Ширхэгийн хэмжээ, мм							Механик бүрэлдэхүүн
		1.0-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	<0.01	
Дээж-01	0-20	57.9	28.0	3.1	6.8	1.0	3.3	11.0	Элсэнцэр

Хөрсөн дэх хүнд металлын агууламж, бохирдол: Хөрсний бохирдлын гол үзүүлэлт болох хүнд металлууд нь задарч алга болдоггүй хөрсөнд удаан хугацаанд хадгалагдаж усаар, агаарын тоосонцороор дамжин мал, амьтан, хүний бие организмыг хордуулдаг тул тус компанийн үйл ажиллагаанаас хөрсийг хүнд металлаар бохирдуулж буй эсэхийг тогтоох нь чухал ач холбогдолтой. Иймд үйлдвэрийн талбайгаас дээж авч хүнд металлын агууламжийг үндсэн 6 элементээр тодорхойлон Монгол улсын стандарт “Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ (MNS 5850:2008)”-ний хүлцэх агууламжтай харьцуулалт хийлээ.

Хүснэгт 7. Хөрсөн дэх зарим хүнд металлын агууламж (мг/кг)


Дээж авсан цэг	Гүн /см/	Хүнд металлын агууламж (мг/кг)					
		Хром (Cr)	Хар тугалга (Pb)	Кадми (Cd)	Цайр (Zn)	Зэс (Cu)	Никель (Ni)
Дээж-01	0-30	-	4.1	-	62.4	17.0	2.1
Монгол улсын стандарт (MNS 5850 : 2008)	Зөвшөөрөгдөх хэмжээ	150	100	3	300	100	150
	Хортой агууламж	400	500	10	600	500	500
	Аюултай агууламж	1500	1200	20	1000	1000	1800

Хөрсөн дэх хүнд металлын шинжилгээнээс үзэхэд Кадми (Cd) болон Хром (Cr) илрээгүй, бусад хүнд металлуудын агууламж стандартад заагдсан элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй хөрсөнд байх ЗДХ-ээс харьцангуй бага буюу хүнд металлын бохирдол илрээгүй байна.

2.4. Гадаргын болон газар доорх усны нөөц, онцлог, чанар

2.4.1. Гадаргын усны горим

Монгол орны гол, мөрөн, түүний сав газрын хэмжээ, байгалийн нөхцөл, урсац бүрэлдэх зүй тогтол, нөөцийн хуваарьлалт, байгалийн болон засаг захиргааны хил хязгаарыг үндэслэн Байгаль орчин, Аялал жуулчлалын сайдын 2009 оны 332 дугаар тушаалаар Монгол орны нутаг дэвсгэрийг усны 29 сав газарт хувааж, хил хязгаарыг нь тогтоож өгсөн байдаг. “Бетон зуурмагийн үйлдвэр” – ийн эзэмшил газар нь Туул голын сав газарт хамаарах ба Туул голын хойд талд 1 км орчим зайд байрладаг. Харин үйлдвэрийн талбайн хойд талаар 450 м орчим зайд Дунд гол урсан өнгөрөөд Туул гол руу цутгадаг. Үйлдвэрийн талбай нь усан сан бүхий газрын энгийн болон онцгой хамгаалалтын бүсэд ороогүй байна.



Зураг 20. Төслийн талбайн орчны гадаргын усан сүлжээний зураглал

Туул голын сав газар нь Монгол орны төв хэсэгт орших бөгөөд Хэнтийн нурууны баруун хэсгийн салбар уулсаас эх авсан олон гол горхийн усыг цуглуулан Хойт мөсөн далайн ай савд багтах Сэлэнгэ мөрний цутгал Орхон голд цутгадаг.

Голын ус хурах талбай 49774.3 км^2 , урт нь 717.0 км , хэвгий 0.0015 , 6-р эрэмбийн гол юм. Голдрилын дундаж өндөр 1160 м , ус хагалбарын шугамын урт 2055.6 км , түүний дундаж өндөр 1719.0 м , голуудын нийлбэр урт 11046.5 км , усан сүлжээний нягтшил 0.23 км/м^2 , ус хурах талбайн дундаж өндөр 1300.0 м , хөндий гүн дунджаар 559.0 м , түүний өргөн 54.4 км , сав гарын суналтын зэрэг 16.5 , ус хагалбарын шугамын хөгжлийн зэрэг 2.6 , хажуугийн хэрчигдэл 0.8 , Хортоны хуулийн голын тоо, урт, ус хурах талбайн харьцаа 4.2 , 3.05 , 5.58 тус тус байна.

Туул голын тэжээлийн 25% -ийг ул хөрсний ус, 6% -ийг хайлсан цасны ус, 69% -ийг хур борооны ус эзлэх ба усны горимын хэв шинж нь хаврын шар усны ба зуны хур борооны үеийн горимтой голд хамаарна. Голын урсац бүрдүүлэх үндсэн хүчин зүйл нь хур тунадас тул усны түвшин ихээхэн тогтворгүй байдаг. Тухайлбал 4 дүгээр сарын сүүлч, 5 дугаар сарын эхээр хаврын шар усны үер ажиглагдах боловч үргэлжлэх хугацаа, урсацын хэмжээгээр бага байдаг. Хаврын шар усны үерийн дараагаар нэг хэсэгтээ зуны гачиг үе ажиглагдах бөгөөд 7-9 дүгээр сар хүртэл зун, намрын борооны үер залгаснаар голын усны түвшин эрс дээшилнэ.

Борооны үерийн их түвшин шар усны үерийн түвшингээс $1.5-2.0$ дахин их байдаг. Хур борооны үер дууссаны дараа мөсний үзэгдэл үүсэх хүртэл усны түвшин аажим буурч өвлийн гачиг үе эхэлнэ. Голын мөсний үзэгдэл 10 дугаар сарын сүүлчийн арав хоногт эхэлж, 11 дүгээр сарын хоёрдугаар арав хоногт бүрэн хадаалан 4 дүгээр сарын сүүлч хүртэл 122 хоног мөсөн бүрхүүлтэй байна.

Олон жилийн дундаж урсац нь Улаанбаатар хот орчмоор дунджаар 25.6 м³/с байна. Жилийн дундаж урсац нь 5 хувийн хангамшилтай буюу элбэг устай жилд 56.4 м³/с хүрэх ба 97 хувийн хангамшилтай буюу бага устай жилд 6.0 м³/с болж буурна.

2.4.2. Гидрогеологийн нөхцөл

Туул голын сав газрын хэмжээнд нүх сүвийн (бүрдэл), ан цавын (бүс) гэсэн үндсэн 2 төрлийн ус агуулагч бүрдэл тархсан ба ан цав-нүх сүвийн ус болох рашаан (Улаанбаатар, Ар Жанчивлан зэрэг нүүрс хүчилт хүйтэн рашаан) тархсан байна.

Нүх сүвэрхэг бүрдэл нь доод цэрд, неоген, дөрөвдөгчийн хурдас дотор, ан цавлаг бүс нь кембри, девон, карбоны тунамал, хувирмал, эсвэл юра, триасын түрмэл чулуулаг дотор тус тус бүрэлддэг.

Туул голын сав газрын хэмжээнд тархсан хурдас чулуулгийн нас, литологийн төрлийг нэлээд ерөнхийлөн нэгтгэж, тэдгээрийг нүх сүвшилт зонхилсон, эсвэл ан цавшилт зонхилсон байдлаар нь ангилж, газрын доорх усны судлагдсан түвшин, хөдөлгөөний төрхийг харгалзан ус агуулагч нүх сүвэрхэг 6 үе, бүрдэл болон ус агуулагч ан цавлаг 2 бүсээр ялган, тэдгээрийн үндсэн өгөмжийг доорх хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 8. Сав газрын ус агуулагч үе, бүрдэл болон бүсийн гидрогеологийн зарим үзүүлэлт

№	Ус агуулагч үе, бүрдэл, бүсийн нэр	Өгөмжийг нь ашигласан цооногийн тоо	Усны түвшин (бага-их), м	Түвшин бууралт (бага-их), м	Ундарга, л/с	Усны эрдэсжилт, г/л
1	Голоцений аллювийн үе	300	0.2-6.0	0.0-23.0	1.0-105.0	0.1-0.6
2	Туул голын хөндий дагаж тархсан плейстоцений пролювийн, пролюви-аллювийн үе	200	2.0-11.5	1.9-20.5	0.5-24.1	0.5-1.5
3	Цутгал голуудын хөндий дагаж тархсан голоцени-плейстоцений аллюви, пролювийн үе	270	0.2-12.0	2.0-40.0	0.5-8.0	0.3-1.2
4	Неогений хурдас дахь бүрдэл	20	19.37-119	2.0-40.0	0.5-3.8	0.5-1.6
5	Цэрдийн хурдас дахь бүрдэл	85	1.5-80.0	-	0.3-10.0	-
6	Триас-юрагийн давхраадаст чулуулаг дахь бүрдэл	45	3.0-33.0	1.0-15.0	1.0-1.3	0.2-0.3
7	Палеозойн тунамал, хувирмал, бялхмал чулуулаг дахь бүс	30	3.7-60.0	4.5-17.0	0.07-25	0.1-1.2
8	Түрмэл чулуулаг дахь бүс	115	8.6-26.5	2.7-5.1	0.1-4.3	0.1-0.7

2.4.3. Газрын доорх усны нөхөн сэргээгддэг нөөц

Газрын доорх усны нөхөн сэргээгддэг нөөц гэж жил бүр хур тунадсын нэвчилт, гадаргын усны нэвчилт шүүрэлт, хажуугийн урсацын нөлөөгөөр дахин бүрэлдэх боломжтой усны хэмжээг хэлнэ.

Нөхөн сэргээгддэг нөөц нь тухайн нутгийн агаарын хур тунадас, уур амьсгал, гол, горхийн нөлөө, хөрс чулуулгийн онцлогоос хамаарч газрын доорх усанд орж буй усны тэжээгдлийн хэмжээг илэрхийлдэг бөгөөд байнгын бус хэмжигдэхүүн, мөн нөөц хуримтлагдах геологи-гидрогеологийн таатай нөхцөл бүрдсэн тохиолдолд ашиглах боломжтой нөөц юм.

Туул голын сав газрын ус хурах нийт талбай 49774.0 км² бөгөөд жилд 960.0 сая.м³ газрын доорх усны нөхөн сэргээгддэг нөөц бүрэлддэг байж болох тооцоо гарч байна.

Тус сав газарт Улаанбаатар хот, Зуунмод хот, мөн 19 сумын төв байрладаг. Эдгээрээс 12 сумын төв нь нөхөн сэргээгддэг нөөцөөр хомс буюу 0-5 мм/жил/км² нөөцтэй талбайд, 2 сумын төв нь 5-10 мм/жил/км² нөөцтэй талбайд, 1 сумын төв 20-50 мм/жил/км² нөөцтэй талбайд, 6 сумын төв нийлмэл бүрдэлтэй буюу 40-80 мм/жил/км² нөөцтэй талбайд тус тус оршдог байна.


Туул голын сав газрын хэмжээнд газрын доорх усны урсацын хамгийн их модуль нь Туул голын эхэн хэсэгт 160 мм/жил/км² хүрдэг ба голын хөндий дагаж 40-100 мм/жил/км², Хэнтийн нурууны эх орчим арай өндөр нөхөн сэргээгддэг нөөцтэй байна.

Хүснэгт 9. Сав газрын газрын доорх усны нөхөн сэргээгддэг нөөц

№	Нөхөн сэргээгддэг нөөцийн төрөл	Талбай, км ²	Газрын доорх усны урсац, мм/жил/км ²	Нөөц, сая.м ³ /жил/км ²
1	0-5 мм/жил/км ²	33,923.0	5	170
2	5-10 мм/жил/км ²	2,512.0	8	20
3	10-20 мм/жил/км ²	2,053.0	15	31
4	20-50 мм/жил/км ²	2,157.0	35	76
5	50-100 мм/жил/км ²	2,859.0	75	214
6	40-160 мм/жил/км ² буюу нийлмэл бүрдэлтэй	6,270.0	40-160	450
	Нийт	49,774.0		960

Энэхүү хүснэгтээс харахад 1км² талбайд 5мм/жил буюу 5000м³/жил хэмжээний нөхөн сэргээгддэг нөөцтэй талбай 33923 км² буюу Туул голын сав газрын нийт талбайн 68.1 хувь, газрын доорх усны нөхөн сэргээгддэг нөөцийн 17.7 хувийг агуулдаг байхад 40-160 мм/жил хэмжээний нөхөн сэргээгддэг нөөцтэй талбай 6270 км² буюу сав газрын нийт талбайн 12.5 хувь, газрын доорх усны нөхөн сэргээгддэг нөөцийн 46.8 хувийг агуулдаг байна.

Газрын доорх усны нөхөн сэргээгддэг нөөцийн ихэнх нь Туул голын хөндийн аллювийн гаралтай хурдас дахь ус агуулагч нүх сүвэрхэг бүрдэл дотор үүсч солигдож байдаг байна. “Бетон зуурмагийн үйлдвэр” болон түүний орчны нутаг дэвсгэр нь газрын доорх усны 10-20 мм/жил нөхөн сэргээгддэг нөөцтэй бүсэд хамаарч байна.



Зураг 21. Үйлдвэрийн талбайн орчны газрын доорх усны нөхөн сэргээгдэх нөөцийн тархалт

2.4.4. Газрын доорх усны чанар

Үйлдвэрийн хашаанд байрлах гүний худгийн уснаас дээж авч усны чанарыг ШУА, Газарзүй-Геоэкологийн хүрээлэнгийн усны шинжилгээний лабораторид шинжлүүлээ. Шинжилгээний дүнгээс үзэхэд гүний худгийн ус нь химийн бүрэлдэхүүнээрээ сульфатын ангийн, кальцийн бүлгийн, 3-р төрлийн, чанарын хувьд цэнгэг, хатуувтар ус байна.

Хүснэгт 1. Гүний худгийн усны шинжилгээний дүн

Анион	1дм ³ -д байгаа			Катион	1дм ³ -д байгаа		
	Мг	Мг-экв	Мг-экв%		мг	Мг-экв	Мг-экв%
Cl ⁻	26.6	0.75	12.87	Na ⁺ +K ⁺	6.3	0.27	4.70
SO ₄ ²⁻	180.0	3.75	64.33	Ca ²⁺	91.2	4.55	78.05
NO ₂ ⁻	0.0	0.00	0.00	Mg ²⁺	12.2	1.00	17.15
NO ₃ ⁻	8.0	0.13	2.21	NH ₄ ⁺	0.0	0.00	0.00
CO ₃ ²⁻	0.0	0.00	0.00	Fe ²⁺	0.0	0.00	0.00
HCO ₃ ⁻	73.2	1.20	20.59	Fe ³⁺	0.1	0.01	0.09
Дүн	287.8	5.83	100.00	Дүн	109.7	5.83	100.00

2.5. Ургамлан нөмрөгийн өнөөгийн байдал

Улаанбаатар хотын нутаг дэвсгэр нь Монгол орны ургамал-газарзүйн мужлалаар Монгол Дагуурын уулын ойт хээрийн тойрогт (Зураг 22) ургамалжилтаараа өндөр уулын бүсэд хамрагдана. Энэ тойрогт ой, уулархаг хээрийн ургамал зонхилон тархсан байдаг бөгөөд нийт Монгол-Дагуурын уулын ойт хээрийн тойрогт тохиолдох боломжтой 33 зүйл ургамал тэмдэглэгдсэн байдаг. Үүнд: Хөх ногоон дааган сүүл, Хэвтээ биелэг өвс, Торлогийн улалж, Таушийн хус, Монгол хус, Элдэв навчит тарна, Дагуур тооронцор, Норвеги гичгэнэ, Буриад харгана, Тугариновын ортууз, Бараан ноной, Хурц банздоо, Хавтаг навчит хөх

толгой, Торлог чирэг, Зарзаахай харцагана, Өдлөг могодоохой, Үндэслэдэг зэгс, Дуулгачивт цахирам, Бяцхан цэцэгт хорголжин, Хөдөөгийн туурам, Нугын хошоонгор, Толбот цэгцүүхэй, Охоотын чөдөр өвс, Монньегийн халгацай, Ботуульхай шагшуурга, Туурасны харуу цэцэг, Хаврын салжир, Сукачевын зохимон, Ганешиний харцгана, Крыловын гандбадраа, Сэлэнгийн шарилж, Дагуур тооронцор, Унжгар азаргана, Мухар банга зэрэг орно.

1989 оны Н.Өлзийхутаг гуайн судалгаагаар энэ тойрогт 946 зүйл ургамал бүртгэгдсэний дотор жинхэнэ ба завсрын унаган ургамал 10 зүйлийг тодорхойлсон байна. Үүнд: Монгол хундага, Турьхан хус, Валерийн тарна, Халх гичгэнэ, Бяцхан навчит харгана, Сэлэнгийн ортууз, Цагаан цэцэгт хүн хорс, Борнуурын багваахай, Элдэв хэлбэрт багваахай, Монгол багваахай зэрэг ургамлууд тохиолдоно.

Бетон зуурмагийн үйлдвэрийн үйл ажиллагаа явуулж буй талбай нь Монгол – Дагуурын уулын ойт хээрийн тойрогт хамаарагдах боловч антропоген болон техноген нөлөөлөлд өртөж, ямар ч ургамлан нөмрөггүй, сул шороон гадаргатай болсон. Тус талбай нь Туул голын өргөн хөндийд байрлалтай тул үйлдвэрийн хашааны гадна талаар **голын хөндийн бургас – алаг өвс – ширэг улалжит чийглэг нугын ургамалжилтыг дагаж** модлог ургамлаас Таван дохиурт бургас (*Salix pentanra.L.*) Одой хайлаас (*Ulmus pumila*), Лавр навчит улиас (*Populus laurifolia Ldb*), өвслөг ургамлаас ширэг улалж (*Carex duriuscula C.A.MeyC. korshinskyi, C. pediformis.*) гэсэн 3 зүйл, еremogone capillaris, гичгэнээс (*Potentilla acaulis, P.sericea, P.bifurca, P.anserina L*), Багваахай (*Taraxacum mongolicum*), Нугын Биелэг (*Poa pratensis L.*) Нугын шимтэглээ (*Geranium pratense L.*) зэрэг ургамлууд түгээмэл тохиолдоно.



Зураг 22. Үйлдвэрийн хашааны гадна талын ургамалжилтын байдал

2.6. Амьтны аймгийн тархалт, зүйлийн бүрдэл

ХУД-ийн 3-р хорооны нутаг дэвсгэрт байрлах “Ноц бетон зуурмаг” ХХК-ийн бетон зуурмагийн үйлдвэрийн талбайн орчим нь хүн ам, үйлдвэр үйлчилгээний суурьшлын бүс тул хөхтөн амьтан байхгүй. Харин шувуудын дотроос тоо толгойн хувьд оронгийн (*P.domesticus*) ба хээрийн (*P.montanus*) бор шувуу, хөхвөр тагтаа

(C.livia), сохор элээ (Milvus migrans), шаазгай (Pica pica), улаан хошуут (Pyrrhocorax pyrrhocorax), хар хэрээ (Corvus corone), хон хэрээ (Corvus corax) зэрэг шувууд тохиолдоно.


Улаанбаатар хот нь байгалийн унаган төрхөө алдсан, хүний хиймэл орчин бүрдээд удаж байгаа учир үйлдвэрийн үйл ажиллагаанаас шувуудын тархалт, зүйлийн бүрдэлд нэмж сөрөг нөлөө үзүүлэхгүй.

Мөн тухайн орчимд Монгол улсын болон олон улсын хууль тогтоомж, конвенцуудын хавсралтанд орсон ховор зэрэглэлийн болон агнуурын ач холбогдолтой ан амьтан байхгүй болно.

2.7. Нийгэм, эдийн засгийн өнөөгийн байдал

“Ноц бетон зуурмаг” ХХК-ийн Бетон зуурмагийн үйлдвэр нь Хан-Уул дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэрт байрлана.

Нутаг дэвсгэр: Хан-Уул дүүрэг нь 48500 га нутаг дэвсгэртэй, засаг захиргааны 21 хороотой. Газар нутгийн 21.1 хувь буюу 10226 га нь ой мод, гол горхи, рашаан ус бүхий дархлагдсан ногоон бүс, 67.6 хувь буюу 32763 га нь хөдөө аж ахуйн эдэлбэр газар, 11.3 хувь буюу 5499 га нь хот суурин, зам харилцааны сүлжээ, нийтийн эзэмшлийн газарт хамаардаг. Бетон зуурмагийн үйлдвэрийн талбайг газар ашиглалтын ангилалаар нь авч үзвэл Ойн сан бүхий газарт хамаарч байна.




Зураг 23. ХУД-ийн газрын нэгдмэл сангийн ангилал

Хүн ам, хөдөлмөр эрхлэлтийн түвшин: Нийслэлийн хүн ам нь Баянзүрх дүүрэгт, 22.2 хувь нь Сонгинохайрхан дүүрэгт, 15.7 хувь нь Чингэлтэй дүүрэгт, **12.4 хувь нь Хан-Уул дүүрэгт**, 10.9 хувь нь Чингэлтэй дүүрэгт, 10.1 хувь нь Сүхбаатар дүүрэгт, үлдсэн 4.9 хувь нь Налайх, Багануур, Багахангай дүүрэгт тус тус амьдарч байна.

Нийслэлийн хүн амын эзлэх хувь, дүүргээр

2019 оны жилийн эцсийн байдлаар Хан-Уул дүүрэгт 50.722 өрхийн 181090 суурин хүн бүртгэгдсэн бөгөөд 1 км² талбайд ногдох хүн амын нягтрал нь 501.9 байна. Энэ нь 2000 онтой харьцуулахад 3.5 дахин өссөн үзүүлэлттэй гарчээ.



Харин хүн амын хөдөлмөр эрхлэлтийн түвшинг нийслэлийн хэмжээнд авч үзвэл нийт ажиллагчдын 140.3 мянга (27.4 %) нь Баянзүрх, 111.3 мянга (21.7 %) нь Сонгинохайрхан, 78.4 мянга (15.3 %) нь Баянгол, **60.6 мянга (11.8 %) нь Хан-Уул**, 51.1 мянга (10.0 %) нь Сүхбаатар, 48.0 мянга (9.4 %) нь Чингэлтэй, 14.4 мянга (2.8 %) нь Налайх, 8.9 мянга (1.7 %) нь Багануур, Багахангай дүүрэгт байна.

Боловсрол: Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт ерөнхий боловсролын 35 сургууль үйл ажиллагаа явуулж байгаагаас 17 нь төрийн бус, 18 төрийн захиргааны сургууль байна. Эдгээр сургуулиудад нийт 30766 хүүхэд суралцаж байгаа ба нэг багшид дунджаар 22 хүүхэд ногдож байна. Ерөнхий боловсролын нийт суралцагчдын 0.82 хувийг нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд эзэлж байна.

Мөн тус дүүргийн нутаг дэвсгэрт 2018-2019 оны хичээлийн жилд нийт 10 их дээд сургууль, коллеж үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 12281 суралцагч бүртгэгджээ.

Аж үйлдвэр: Хан-Уул дүүрэг нь аж үйлдвэрийн томоохон бүс нутаг бөгөөд дүүргийн нутаг дэвсгэрт 16.403 аж ахуйн нэгж, үйлдвэр, компани, нөхөрлөл, хоршоо үйл ажиллагаа явуулж байна. Тухайлбал “Говь” ХК, “Гоёо” ХХК, “Кашмер Холдинг” ХХК, “МАК” корпораци, “АПУ” ХК, “Витафит” групп, “Таван богд” ХХК, “Атар өргөө” ХК, “Монфрэш” ХХК, “Жем интернейшнл” ХХК, Дулааны 3 дугаар цахилгаан станц” ТӨҮГ, МИАТ ХК, “Зорчигч Тээврийн нэгтгэл” ОНӨҮГ, “Биокомбинат” ОНӨҮГ зэрэг үндэсний томоохон компаниуд үйл ажиллагаа явуулж байна.

Хан-Уул дүүргийн аж үйлдвэрийн газрууд нь 2019 онд нийт 752.1 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 736.6 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь өмнөх оны эцэстэй харьцуулахад үйлдвэрлэлт 24.3 хувиар, борлуулалт 39.6 хувиар өссөн байна.

Хан-Уул дүүргийн аж үйлдвэр, барилга, уул уурхай, эрчим хүч, хөнгөн, хүнс, хөдөө аж ахуйн газрууд нь Монгол Улсын аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэлтийн 7,5 хувь, нийт борлуулалтын 9,2 хувь, Нийслэлийн нийт үйлдвэрлэлтийн 21 хувь, нийт борлуулалтын 20.7 хувийг тус тус үйлдвэрлэж байна.

Мал аж ахуй: Хан-Уул дүүрэгт 2018 оны жилийн эцсийн байдлаар 33208 мал тоологдож өмнөх оноос 5277 толгой буюу 13.7 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Дүүргийн малтай өрхийн тоо 2018 оны байдлаар 700 болж өмнө оноос 13.5 хувиар буурсан бол малчин өрхийн тоо 182 болж өмнөх оноос 18.9 хувиар өссөн үзүүлэлт тус тус гарчээ. Малчдын 21.4 хувь нь 15-34 насны, 63.6 хувь нь 35-59 насны

байхад 15.0 хувийг 60 ба түүнээс дээш насныхан эзэлж байна. Хан-Уул дүүрэгт үндсэн малчин 256, туслах малчин 32 бүртгэгджээ.

Малчдыг боловсролын түвшингээр нь авч үзвэл жилийн эцсийн мал тооллогоор бүртгэгдсэн нийт малчдын 8.8 хувийг дээд боловсролтой иргэд, 50.8 хувь нь бүрэн дунд, 23.3 хувь нь суурь, 8.6 хувь нь техникийн болон тусгай мэргэжлийн, 6.4 хувь нь бага боловсролтой, үлдсэн 2.1 хувь нь боловсролгүй иргэд байна.

Газар тариалан: Нийслэлийн хэмжээнд 2018 онд 160.2 га (20.1%) талбайд төмс, 293.8 га (36.9%) талбайд хүнсний ногоо, 340.9 га (42.8%) талбайд тэжээлийн ургамал тариалсан байна. Тариалалт хийсэн нийт талбайн 57.6 га (7.2%) нь хүлэмжийн талбай байна. 2018 оны тариалсан талбайг ургамлын нэр төрлөөр нь авч үзвэл төмс тариалсан талбай өмнөх оноос 64.6 га (28.7%), хүнсний ногоо 11.5 га (3.8%)-аар, техникийн ургамал 2.5 га-аар буурч, тэжээлийн ургамал 48.7 га (16.7%)-аар өссөн байна.

Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт газар тариалан эрхэлдэг 326 өрх бүртгэгдэж өмнөх оноос 21.6 хувиар өссөн бол тариалан эрхэлдэг 24 аж ахуйн нэгж бүртгэгдэж өмнөх оноос 4 дахин өссөн байна. Мөн ургац хураалтын байдлыг авч үзвэл Хан-Уул дүүрэг нь 2018 онд 390.1 тн төмс, 2987.3 тн хүнсний ногоо хураасан байна.

Төсвийн орлого, зарлага: Хан-Уул дүүргийн 2018 оны төсвийн нийт орлого нь 77610.1 сая.төг байгаагаас 33661.2 сая.төг нь татварын орлого, 1679.6 сая.төг нь татварын бус орлого, 71449.0 сая.төг нь тусламжийн орлого байна. Дүүргийн төсвийн нийт орлого нь өмнөх оноос 3.1 хувиар өссөн үзүүлэлттэй гарсан бөгөөд энэхүү орлогыг голлох төрлүүдээр нь авч үзвэл 75.3 хувийг хүн амын орлогын албан татвар, 7.8 хувийг өмчийн татвар, 13.6 хувийг бусад татвар, хураамж, төлбөр (улсын тэмдэгтийн хураамж, газар, ус, хэрэглээний мод түлээ ашигласны төлбөр, хог хаягдлын үйлчилгээний хураамж), 3.3 хувийг бараа, үйлчилгээний татвар эзэлж байна.

Хүснэгт 10. Хан-Уул дүүргийн 2018 оны төсвийн нийт орлого, сая төгрөг

№	Нийт орлого	Орлогын биелэлтийн хувь	Татварын орлого	Орлогын биелэлтийн хувь	Татварын бус орлого	Орлогын биелэлтийн хувь	Тусламжийн орлого	Орлогын биелэлтийн хувь
1	77610.1	114.3	33661.2	141.3	2582.0	135.8	41366.9	98.1

Хан-Уул дүүргийн 2018 оны төсвийн нийт зарлага нь 68395.2 сая.төг байгаагаас 19407.2 сая.төг нь орон нутгийн төсвийн зарлага 40997.1 сая.төг нь тусгай шилжүүлгийн зарлага, 7990.9 сая.төг нь төвлөрүүлэх шилжүүлгийн зарлага байна.


Хүснэгт 11. Хан-Уул дүүргийн 2018 оны төсвийн нийт зарлага, сая төгрөг

№	Нийт зарлага	Орлогын биелэлтийн хувь	Орон нутгийн төсвийн зарлага	Орлогын биелэлтийн хувь	Тусгай шилжүүлгийн зарлага	Орлогын биелэлтийн хувь	Төвлөрүүлэх шилжүүлгийн зарлага	Орлогын биелэлтийн хувь
1	68395.2	97.0	19407.2	93.7	40997.1	98.0	7990.9	100.0

Хан-Уул дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэрийн нийгэм, эдийн засгийн өнөөгийн байдал:

ХУД-ийн 3-р хороо нь 373 га газар нутаг, 4674 өрх, 16905 хүн амтай. Хойд талаараа Баянгол дүүргийн 3 дугаар хороо, зүүн болон урд талаараа Хан-Уул дүүргийн 2 дугаар хороотой, баруун талаараа Хан-Уул дүүргийн 4 дүгээр хороотой хиллэдэг.

